



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 16 өдөр

Дугаар 1147

Улаанбаатар хот

“Өдөр өнжүүлэх үйлчилгээ эрхлэхэд тавих нийтлэг шаардлага”-ын хэрэгжилтэд хяналт шалгалт хийх Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4 дэх заалт, Боловсролын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5 дахь хэсэг, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 03 дугаар тогтоол, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн А/152 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖДАХ нь:

1. “Өдөр өнжүүлэх үйлчилгээ эрхлэхэд тавих нийтлэг шаардлага”-ын хэрэгжилтэд хяналт тавих, шинээр өдөр өнжүүлэх үйлчилгээ эрхлэх иргэн, хуулийн этгээдэд хяналт шалгалт хийж дүгнэлт гаргах Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй баталсугай.

Ажлын хэсгийн
ахлагч:

Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга

Гишүүд:

Боловсролын хэлтсийн Албан ба албан боловсрол хариуцсан ахлах мэргэжилтэн
Мэргэжлийн хяналтын тасгийн Улсын ахлах байцаагч

Онцгой байдлын хэлтсийн Эрсдлийн удирдлага, үнэлгээ, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн

Нарийн бичгийн
дарга:

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтсийн дарга

2. “Өдөр өнжүүлэх үйлчилгээ эрхлэхэд тавих нийтлэг шаардлага”-ын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Ажлын хэсэг /Б.Цогжавхлан/-т үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч /Б.Болормаа/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА С.Эрдэнэбаяр С.ЭРДЭНЭБАЯР

